



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 3 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар
авах зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.11, 10.1.14-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай:

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах;

1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах, төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарах;

1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулж, гэрээ байгуулсан байхаар тооцож ажиллах;

1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажиллах;

1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарч ажиллах;

1.6. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид холбогдох гэрээ, хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН